



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/143

Номгон

“Зүүн шанд” ХХК-ний эзэмшил газрын
зөрчлийг арилгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын өдрийн 25-ны 135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Зүүн шанд” ХХК-ны хүсэлтийг харгалзан аймгийн Засаг даргын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 186 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсэгт заасан 2760м2 газар дээр илүү эзэмшиж буй 181 м2 газрыг нэмж эзэмшүүлэн, хавсралтаар баталж өөрчилсүгэй.

2. Илүү эзэмшиж буй 181 м2 газрын үнийг төлүүлэн зөрчлийг арилгасугай.

3. Эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-т нарт үүрэг болгосугай.


4. Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлж зориулалтын дагуу зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч “Зүүн шанд” ХХК-ны захирал (Л.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХСАЙХАН

ӨӨРЧЛӨЛТ ОРЖ БҮЙ НЭГЖ ТАЛБАРЫН ЖАГСГАЛТ

Аймгийн засаг дарга 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/143/Т.авг захирлын хавсралт



Эзэмшигчийн газрын мэдээлэл							
№	Нэр	регистрийн дугаар	нэгж талбарын дугаар	талбайн хэмжээ /м2/	талбайн хэмжээ /м2/	Нэмэгдэж буй талбайн хэмжээ м2	Нийт талбайн хэмжээ м2
1	"Зүүн шанд" ХХК	2006642	6409007456	2760 м2	181 м2	2941 м2	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Найрамдлын гудамж-1, 119 тоот
	Зориулалт	Үйлчилгээтэй, орон сууц					